



Монголбанк

Санхүүгийн мэдээллийн алба

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН МЭДЭЭЛЭХ ГАРЫН АВЛАГА

БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГА

2021 оны 3 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНДББ	Ази, Номхон далайн бүсийн байгууллага
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
МУТС	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ФАТФ	Мөнгө угаахтай тэмцэх олон улсын санхүүгийн арга хэмжээ авах байгууллага

АГУУЛГА

1	Танилцуулга	4
1.1	Өмнөх үг	4
1.2	Зорилго	4
1.3	Холбогдох журам, заавар.....	5
2	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх	5
2.1	Мөнгө угаах гэж юу вэ?	5
2.2	Мөнгө угаах 3 үе шат	6
2.3	Мөнгө угаахыг тодорхойлох нь	6
2.4	Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах.....	7
2.5	Террорист үйлдэл гэж юу вэ ?	7
2.6	Терроризмыг санхүүжүүлэхийг тодорхойлох нь.....	7
2.7	Зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	8
2.8	МУТСТ олон улсын эрх зүйн зохицуулалт.....	9
2.9	Дотоодын эрх зүйн зохицуулалт	10
3	Сэжигтэй гүйлгээ	10
3.1	Сэжигтэй гүйлгээг илрүүлэх	11
3.2	Хэн мэдээлэх үүрэгтэй вэ?.....	13
3.3	Юуг мэдээлэх вэ?.....	13
3.4	Яаж мэдээлэх вэ?	14
4	Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах	14
5	Удирдлага болон ажилтнуудад зориулсан сургалт	15
5.1	Сургалтын агуулга.....	16
5.2	Сургалтын арга зүй болон давтамж.....	17
6	Сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд.....	17
6.1	Сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг гэж юу вэ?	17
7	Сэжигтэй гүйлгээний тухай нэмэлт мэдээлэл.....	18
7.1	МУТСТ тухай хуулийн дагуу нэмэлт мэдээлэл авах.....	18
8	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага.....	19
9	Мэдээллийн нууцлалыг задруулах.....	19
10	Хариуцлагаас чөлөөлөх.....	19

1 ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлагыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд болох БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА-д зориулан сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь мэдээлэл, чиглэл өгөх зорилгоор боловсруулав.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын ажилтнууд сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг таних, илрүүлэх, мэдээлэхийн тулд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох, яагаад түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх шаардлагатай талаар ойлгож, сэжигтэй гүйлгээ, оролдлогыг таньж болох түгээмэл шинж тэмдгүүдийн талаар ерөнхий мэдлэгтэй байх шаардлагатай.

Иймд гарын авлагаар сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхэд хууль, журмаар тавигдах шаардлагуудын талаар мэдээлэл өгөхөөс гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой ерөнхий мэдээлэл, мэдлэг олгохыг зорилоо.

1.1 ӨМНӨХ ҮГ

ББСБ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох, хуульд заасан гүйлгээнд тусгай хяналт тавих, сэжигтэй гүйлгээ, 20 сая төгрөгөөс дээш дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг СМА-нд мэдээлэх, хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг хэд хэдэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Энэхүү гарын авлага нь эдгээр үүргүүдээс зөвхөн сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхтэй холбоотой үүргийг таниулж, тайлбарлах болно.

Гарын авлагыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам, Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх тухай журам болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилгот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журамд тус тус нийцүүлэн боловсруулав.

1.2 ЗОРИЛГО

Гарын авлага нь дараах үндсэн гурван зорилготой. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой ерөнхий ойлголт өгөх;
- Сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ)-гаар юуг хэн, хэзээ, хэрхэн мэдээлэх вэ гэдгийг тайлбарлах замаар ББСБ-ын ажилтнуудад хууль, журамд заасан

сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг мэдээлэх үүргээ ойлгох, хэрэгжүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох сэжигтэй гүйлгээний ерөнхий болон бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог бүхий шинж тэмдгүүдийн талаар мэдээлэл өгч, ББСБ-ын ажилтнуудад сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд туслах.

1.3 ХОЛБОГДОХ ЖУРАМ, ЗААВАР

Санхүүгийн мэдээллийн алба нь МУТСТ-тэй холбоотой батлагдсан хууль, журам, боловсруулж гаргасан гарын авлага, заавар зөвлөмжүүдийг өөрийн цахим хуудаст байршуулсан байгаа. Эдгээр баримт бичгүүдийг дараах холбоосуудаар орж авч, ашиглаж болно. Үүнд:

<https://fiu.mongolbank.mn/regulation.aspx>

<https://fiu.mongolbank.mn/reporting.aspx?id=5>

Цахим хуудаст тавигдаагүй, зөвхөн мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хэрэгцээнд зориулан гаргасан баримт бичгүүдийг СМА-ны fiu@mongolbank.mn албан цахим шуудангийн хаяг руу э-мэйл бичиж эсхүл утсаар холбогдож авах боломжтой.

Түүнчлэн Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хороо нь өөрсдийн зохицуулалтад хамаарах мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан гаргасан гарын авлага, заавар зөвлөмж, мэдээ мэдээлэл болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг цахим хуудаснууддаа байршуулсан байдаг тул авч ашиглаарай.

2 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ

2.1 МӨНГӨ УГААХ ГЭЖ ЮУ ВЭ?

Гэмт хэрэг үйлдэж байгаа хувь хүн эсхүл бүлэг этгээдийн олонх нь ашиг хонжоо олох зорилгоор тухайн гэмт хэргийг үйлддэг. Мөнгө угаах гэдэг нь ийнхүү гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогын хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хууль ёсоор олсон орлого мэт харагдуулах үйл явц юм. Энэ үйл явц нь гэмт хэрэгтнүүдэд гэмт хэргийн замаар олсон ашиг, орлогоо хууль бус эх үүсвэрийг нь мэдэгдэлгүй ашиглах, захиран зарцуулах боломж олгодог.¹

Хууль бусаар зэвсэг худалдаалах, хил давуулах болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын наймаа, биеэ үнэлэх зэрэг зохион байгуулалттай гэмт хэргүүдээс маш их хэмжээний орлого олдог. Түүнчлэн залилах, хулгайлах, хөрөнгө завших, авлигын гэмт хэрэг үйлдэх, үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж арилжаанд оролцох зэрэг бусад гэмт хэргүүдээс ч мөн их хэмжээний ашиг олдог бөгөөд гэмт хэрэгтнүүд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө асуудалгүй ашиглахын тулд мөнгө угаах замаар хууль ёсоор олсон мэт болгох арга зам хайна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж хөрөнгө, ашиг орлого олсон хувь хүн эсхүл бүлэг этгээд нь хууль, хяналтын байгууллагын анхаарлыг хийсэн

¹ <http://www.fatf-gafi.org/faq/moneylaundering/#d.en.11223>

хэрэг, хэрэг үйлдсэн этгээд рүү татахгүйгээр хууль бус хөрөнгө, орлогоо эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг санаархдаг. Ингэхдээ тэд хөрөнгө, ашиг орлогынхоо хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хэлбэр дүрсийг нь өөрчлөх, эсхүл анхаарал бага татахуйц газар луу шилжүүлдэг байна.

Ийнхүү гэмт хэрэг үйлдэж олсон эсхүл хууль бус үйл ажиллагаанаас олсон хөрөнгө, ашиг орлогын хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах үйл явцыг мөнгө угаах гэж ойлгож болно. Дээр өгүүлсэнчлэн мөнгө угаах үйл ажиллагаа нь гэмт хэрэгтнүүдэд гэмт хэргээс олсон орлогоо чөлөөтэй ашиглаж, хуулийн хариуцлагаас зугатах боломжийг олгодог.

2.2 МӨНГӨ УГААХ 3 ҮЕ ШАТ

Дараах гурван үе шатны дагуу мөнгө угаадаг гэж үздэг. Үүнд:

1. Байршуулах: Хамгийн эхлээд гэмт этгээд нь хууль бусаар олсон хөрөнгө, мөнгөө санхүүгийн системд оруулах буюу байршуулна. Ингэхдээ их дүнтэй мөнгийг хуваан бага бага дүнгээр банк, санхүүгийн байгууллагын дансанд хийх, замын чек гэх мэт төлбөрийн хэрэгслүүд худалдан авч, дараа нь өөр газар сольж мөнгийг нь дансанд хийх зэрэг арга замаар банк, санхүүгийн системд байршуулна.
2. Нуун далдлах: Дараагийн үе шатанд гарал үүслийг нь нуун далдлах, хууль бус эх үүсвэрээс нь аль болох холдуулах зорилгоор нэгэнт байршуулсан мөнгөө ийш тийш шилжүүлэх эсхүл хувиргана. Жишээ нь: хөрөнгө оруулалтын хэрэгсэл худалдан авах, зарах эсхүл хууль ёсны мэт харагдуулах зорилгоор гадаад худалдааны төлбөр тооцоо мэт утгатай гадаад шилжүүлгүүдийг мөнгө угаахтай тэмцэх хяналтын тогтолцоо муутай гадаад орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэдэг.
3. Буцаан төвлөрүүлэх: Гэмт этгээд гэмт хэргээс олсон орлогоо дээр дурдсан хоёр шатанд амжилттай нэвтрүүлсний дараа гурав дахь буюу буцаан төвлөрүүлэх үе шатанд хөрөнгө, мөнгөө өөрийн болон хамаарал бүхий этгээдийн нэр дээр буцаан төвлөрүүлж авдаг бөгөөд хууль ёсны санхүүгийн системд дахин нэвтрүүлдэг. Нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны мэт харагдах болсон хөрөнгө, мөнгөөрөө үл хөдлөх хөрөнгө эсхүл тансаг зэрэглэлийн хөрөнгө худалдан авах, эсхүл аль нэг бизнесд хөрөнгө оруулах зэргээр эзэмшиж, ашиглаж эхэлдэг аж.

Мөнгө угаах гэмт хэрэг нь ерөнхийдөө дээрх гурван үе шатаар дамждаг боловч заавал бүх үе шатыг хамрах шаардлагагүй тохиолдол ч байдаг байна.

2.3 МӨНГӨ УГААХЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-г мөнгө угаахыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

“мөнгө угаах гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмисэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх

үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байриил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг”.

2.4 ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН МӨНГӨ УГААХ

Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах аль ч тохиолдолд гэмт этгээдүүд хууль бус эх үүсвэрээс олсон хөрөнгө, мөнгөө аль болох хяналт, шалгалт багатай гэж үзсэн газраар дамжуулан шилжүүлэх сонирхолтой байдаг. Иймд ББСБ-ын ажилтнууд мэдлэг, мэдээлэл сайтай байж, маш сайн хяналт тавих шаардлагатай бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, тавьдаг хяналтаа ижил түвшинд хийх шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үйлдэгдэж буй арга хэлбэр нь ижил төстэй боловч агуулгын хувьд энэ хоёр гэмт хэрэг ялгаатай.

Мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэхэд террорист этгээд эсхүл байгууллага нь гэмт хэрэг үйлдэж мөнгө олохоос гадна хууль ёсны эх үүсвэрээр ч мөнгө босгодог. Түүхээс харвал терроризмыг санхүүжүүлэгчид нь албан бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, буяны байгууллагууд, бэлэн мөнгө зөөвөрлөгчдийг ашиглах гэх мэтээр гүйлгээг хууль ёсны мэт харагдуулах эсхүл нарийн төвөгтэй байдлаар хийх зэрэг тусгай аргуудыг ашиглаж байжээ.

2.5 ТЕРРОРИСТ ҮЙЛДЭЛ ГЭЖ ЮУ ВЭ ?

Террорист үйлдлийг “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх” тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т: дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

“террорист үйлдэл гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төр, олон улсын байгууллагаас хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардаж хүн амыг айдаст автуулах, хүнийг алах, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахыг;”.

2.6 ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т терроризмыг санхүүжүүлэхийг дараах байдлаар томъёолсон. Үүнд:

“терроризмыг санхүүжүүлэх гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;”.

2.7 ЗОРИЛТОТ САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам” нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан 1267 дугаар тогтоол болон түүний дагалдан гарсан тогтоолуудын дагуу НҮБ-аас жагсаалтад оруулсан, 1373 дугаар тогтоол болон түүний дагалдан гарсан тогтоолуудын дагуу Монгол Улсаас жагсаалтад оруулсан иргэн болон хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах эрх зүйн хүрээгээр хангадаг. (эдгээр нь бүхэлдээ санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ).

Санхүүгийн хориг арга хэмжээтэй холбоотой “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

- i/ Хүн, хуулийн этгээд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан тогтоол, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Засгийн газраас баталсан тагнуулын байгууллагаас гаргасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдэгдэнэ.
- ii/ Санхүү, бизнесийн этгээд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан тогтоол, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Засгийн газраас баталсан тагнуулын байгууллагаас гаргасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсхүл түүнийг төлөөлж буй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- iii/ Санхүү, бизнесийн этгээдээс энэ журмын i/ii-т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг зогсооно:
 - Зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
 - Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
 - Энэ журмын iii хэсгийн эхний 2-т заасан хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;
 - НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолоор жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл.

2.8 МУТСТ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.8.1 ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

МУТСТ-тэй холбоотой хэд хэдэн олон улсын стандарт, баримт бичгүүд батлагдсан байдаг. Үүнд:

- *Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймааны эсрэг гаргасан НҮБ-ын конвенц – Венийн конвенц – 1988 он;*
- *Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц – Палермогийн конвенц – 2000 он;*
- *Авлигатай тэмцэх НҮБ-ын конвенц – 2005 он;*
- *ФАТФ-ын 40 Зөвлөмж (2012 он).*

2.8.2 МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА - ФАТФ

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /The Financial Action Task Force FATF -ФАТФ/ нь 1989 онд гишүүн улс орнуудын сайд нарын байгуулсан олон улсын засгийн газар хоорондын байгууллага юм.

ФАТФ-ын зорилго нь олон улсын санхүүгийн системийн нэгдсэн байдалд аюул, занал учруулж байгаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон бусад холбогдох аюул заналхийлэлтэй тэмцэх хууль, эрх зүйн, зохицуулалтын болон үйл ажиллагааны стандартыг тогтоон хэрэгжүүлэхэд оршдог. Улс орнууд ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

Өөрөөр хэлбэл, ФАТФ-ын зөвлөмж нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхэд улс орны хэрэгжүүлэх шаардлагатай иж бүрэн, цогц арга хэмжээний ерөнхий хүрээг тодорхойлдог. Улс орнуудын хууль эрх зүй, засаг захиргаа, нийгэм, эдийн засгийн тогтолцоо болон санхүүгийн систем харилцан адилгүй тул дээр дурдсан аюул заналхийлэлтэй тэмцэх арга хэлбэр нь ч харилцан адилгүй юм. Иймд ФАТФ-ын зөвлөмж нь улс орнууд өөрийн онцлог нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх олон улсын стандартыг тогтоож өгсөн гэж ойлгож болно.

Монгол Улсын хувьд ФАТФ-ын бүс нутгийг хариуцсан салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (АНДББ)-ын гишүүн юм.

Жич: ФАТФ-ын 40 Зөвлөмжийг ФАТФ-ын цахим хуудсаас татаж авах боломжтой². Түүнчлэн СМА-наас ФАТФ-ын 40 Зөвлөмж буюу “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг

² FATF Recommendations 2012

<http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf>

санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт”-ыг орчуулан цахим хуудсанд байршуулсан³.

2.9 ДОТООДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ББСБ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхдээ дараах хууль, журмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

- ✓ *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;*
- ✓ *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;*
- ✓ *Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;*
- ✓ *Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх тухай журам;*
- ✓ *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам.*

3 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭ

ББСБ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу дараах тохиолдолд сэжигтэй гүйлгээг СМА-нд мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

“Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол”.

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (СГТ)

ББСБ нь гүйлгээ эсхүл гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг Сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

СМА-ны хувьд МҮЭ-ээс ирүүлж байгаа СГТ нь тухайн сэжиглэж буй гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагааг судлах, дүн шинжилгээ хийхэд мэдээллийн гол эх сурвалж болдог. Мөн СГТ нь сэжиглэж буй гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа нь нэг гүйлгээгээр хийгдсэн үү эсхүл хоорондоо холбоо бүхий хэд хэдэн гүйлгээгээр хийгдсэн үү гэх зэрэг тодорхой мэдээллүүдийг өгдөг.

СМА нь МҮЭ-ээс ирүүлсэн СГТ-ийн сэжиглэх үндэслэл, тайлбар болон бусад мэдээлэл, үзүүлэлтүүдэд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох ерөнхий эрсдэлийг үнэлэх бөгөөд эрсдэлийн оноо өндөр авснаас эхлэн тухайн гүйлгээ, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй, мөнгө угаах, терроризмыг

³ <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/Mongolian%20Translation%20FATF%20Recommendations%20mng.pdf>

санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх хангалттай үндэслэлтэй эсэхэд дүн шинжилгээ хийдэг.

СГТ-нд дүн шинжилгээ хийх явцад СМА нь сэжигтэй гүйлгээнд холбогдсон этгээдийн талаарх нэмэлт мэдээллийг МҮЭ-ээс авах шаардлагатай байдаг. Эдгээр нэмэлт мэдээлэл нь тухайн сэжиглэх үндэслэл нь үнэхээр гэмт хэргийн шинжтэй байгаа эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Дүн шинжилгээний үр дүнд сэжиглэж буй гүйлгээ эсхүл гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой байж болзошгүй хангалттай үндэслэлтэй байна гэж үзвэл СМА нь хууль тогтоомжийн дагуу холбогдох хууль сахиулах байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

ЖИЧ: СГТ-г гүйлгээ хийгдсэн болон гүйлгээ хийхийг завдсан аль ч тохиолдолд мэдээлэх шаардлагатай бөгөөд сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тогтоосон босго гүйлгээний дүн гэж байхгүй.

3.1 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ ИЛРҮҮЛЭХ

Сэжигтэй гүйлгээ нь ихэвчлэн харилцагчийн өмнө хийж хэвшсэн гүйлгээ, үйл ажиллагаа, хувийн хэрэг эсхүл ажил, мэргэжил, бизнесийн үйл ажиллагаатай нь нийцээгүй гүйлгээ байдаг.

Ихэнх тохиолдолд ББСБ-ын ажилтан нь харилцагч яг ямар гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа хийж байгааг мэдэх боломжгүй байх нь бий. Гэхдээ гүйлгээнүүд болон тэдгээрийг хийж байгаа арга хэлбэрийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой танигдсан типологи, арга хэлбэр, сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдэгтэй тохирч байгаа эсэхийг ажиглаж шалгаснаар аль нэг төрлийн гэмт хэргийн шинжтэй байгааг таамаглаж, сэжиглэж болно. Гүйлгээ нь дангаар нь авч үзэхэд сэжиг төрүүлэхгүй боловч цогцоор нь авч үзэхэд гэмт хэргийн шинжтэй байх боломжтой олон төрлийн хүчин зүйлстэй холбоотой байх нь ч бий.

ББСБ-ын ажилтнууд СМА-наас гаргасан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд” гарын авлагад дурдсан сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдгийн жагсаалтаас ямар гүйлгээ сэжигтэй гүйлгээ байж болох талаар мэдээлэл авч болно. Гэхдээ эдгээр жишээ, жагсаалт нь зөвхөн мэдээлэл, чиглэл өгөх зорилгоор жагсаасан түгээмэл жишээнүүд бөгөөд сэжигтэй байж болзошгүй нөхцөл байдал нь эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй болохыг анхаарна уу. Эцсийн дүнд ББСБ-ын ажилтнуудын мэдлэг, харилцагч болон түүний хийж буй гүйлгээг таньж мэдсэн, судалсан байдал л тухайн гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэх үндэслэлтэй эсэхийг тодорхойлохыг анхаарах нь зүйтэй.

3.1.1 СЭЖИГЛЭХ ҮНДЭСЛЭЛ

ББСБ-ын ажилтан нь харилцагчийн хийж байгаа / хийхийг завдаж буй гүйлгээтэй холбоотой үүсэж буй нөхцөл байдал (context) болон тухайн харилцагчийн талаарх ББСБ-ын ажилтны мэдэж байгаа, олж авч чадах баримт мэдээлэл (fact) буюу харилцагчийн хувийн хэрэг, ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн түүх, өмнө хийж байсан гүйлгээний түүх зэрэг мэдээлэлд үндэслэн өөрийн итгэл үнэмшлийн дагуу сэжиглэх үндэслэлийг тогтоож, сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлагатай.

ББСБ-ын ажилтны авч хэрэгжүүлсэн харилцагчийг таньж мэдэх (ХТМ) ажиллагааг харилцагч, гүйлгээний талаарх мэдлэг, мэдрэмж, мэдээллээр баяжуулах ба энэ нь ББСБ-ын ажилтанд сэжигтэй гүйлгээг таньж мэдэхэд чухал ач холбогдолтой.

СМА-нд мэдээлэгдэх СГТ бүр тухайн харилцагч, гүйлгээг яагаад сэжиглэж буй талаар тайлбарласан бөгөөд тодорхой үндэслэлтэй байх ёстой. Тухайлбал, тодорхой үндэслэлгүйгээр зөвхөн “өндөр дүнтэй гүйлгээ хийж байгаа” гэсэн шалтгаанаар сэжиглэх нь хангалтгүй юм. Харин харилцагчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн болон өмнө хийж хэвшсэн гүйлгээний талаарх мэдээлэлтэй нийцэхгүй байгаа өндөр дүнтэй гүйлгээг сэжигтэй гэж үзэх боломжтой. Энэ тохиолдолд тухайн гүйлгээг өмнөх гүйлгээний мэдээлэлтэй нь харьцуулах, мөн харилцагчийн ажил, бизнесийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд тухайн гүйлгээ хийгдэх нь хэвийн эсэхийг үнэлэх нь бодитой бөгөөд оновчтой сэжиглэх үндэслэлийг бий болгох боломжтой. Өөрөөр хэлбэл, ББСБ-ын ажилтан нь харилцагч, гүйлгээтэй холбоотой СГТ-г бэлтгэж, мэдээлэхээс өмнө тухайн харилцагч, гүйлгээг шалгаж, өөрт байгаа болон цуглуулж чадах мэдээллийн хүрээнд анхан шатны дүн шинжилгээ хийж, сэжигтэй гэж үзэж болох шинж тэмдгүүдийг сайтар судлан сэжигтэй байж болзошгүй хангалттай үндэслэл байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх шаардлагатай. Ингэсэн тохиолдолд ББСБ-ын ажилтан нь харилцагч, гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эсхүл хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэгт холбоотой байж болзошгүй гэж үзэх тодорхой үндэслэлтэй болох юм.

ББСБ-ын мэдээлсэн СГТ дахь сэжиглэх тодорхой үндэслэл болон яагаад харилцагч, гүйлгээг сэжигтэй эсхүл сэжигтэй байж болзошгүй гэж үзсэн талаар бичсэн тайлбар нь СМА-нд тухайн СГТ-нг, сэжиглэх үндэслэлийг ойлгоход нь тус дөхөм болох юм. Цаашлаад СМА уг СГТ-нг дүн шинжилгээ хийхээр сонгох эсэх, өндөр эрсдэлтэй гүйлгээ мөн эсэх, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн дүн шинжилгээ хийх эсэх, хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах эсэхийг шийдэхэд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад суурь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход чухал ач холбогдолтой.

Сэжигтэй гүйлгээг ББСБ-ын ажилтан, комплаенсын мэргэжилтэн эсхүл гүйлгээ, данс хянах үйл явцаар илрүүлж болно. ББСБ-ын ажилтан харилцагч, гүйлгээг сэжигтэй байна гэж үзсэн тохиолдолд түүний ажигласан, тогтоосон нөхцөл байдал (гүйлгээнээс гадна харилцагчийн харилцаа, зан төлөв хэвийн байсан эсэх, нэг дор олон теллер сольж үйлчлүүлсэн эсэх гэх мэт) болон сэжиглэх үндэслэл нь СГТ-нд тусгагдсан байх нь чухал. ББСБ-ын ажилтан болон комплаенсын мэргэжилтэн хоёрын хоорондын харилцаа нь сэжиглэх үндэслэлийн суурийг баталгаажуулахад туслах боломжтой. Ингэснээр СГТ-нг СМА-нд мэдээлэхээс

өмнө тухайн гүйлгээнд хууль, журмын дагуу нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг дотооддоо хянаж үзэх юм.

3.2 ХЭН МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан бүх МҮЭ /доор жагсаалтаар харуулав/ нь сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

4.1.1. банк;

4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.1.4. хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;

4.1.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7. үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

4.1.9. нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:

4.1.9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

4.1.9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;

4.1.9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

4.1.9.д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

Гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг сэжигтэй байна гэж үзсэн тохиолдолд хэн тайлан бөглөх, хэн хянах, хэн эцсийн шийдвэр гаргах вэ гэдгийг ББСБ өөрийн дотоод журам, хөтөлбөрт заасны дагуу шийдвэрлэнэ.

3.3 ЮУГ МЭДЭЭЛЭХ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу СГТ дараах мэдээллийг агуулах шаардлагатай. Үүнд:

- *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан МҮЭ-ийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;*
- *харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;*
- *тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;*

- *тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;*
- *холбогдох бусад баримт бичиг.*

ББСБ нь хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор Сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

Хуульд заасан 24 цагийн шаардлага нь ББСБ-ын ажилтан гүйлгээг шалгаж, дансанд хяналт тавих явцад тухайн гүйлгээг бодитой сэжиглэх үндэслэлтэй байна гэж үзсэн эсхүл мэдсэн цагаас тооцогдож эхэлнэ.

ББСБ нь харилцагчийн гүйлгээг СГТ-аар мэдээлсний дараа тухайн харилцагчтай бизнес харилцаагаа үргэлжлүүлж болно. Гэхдээ ББСБ, түүний удирдлага, ажилтан нь СМА-нд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно. Өөрөөр хэлбэл, сэжигтэй гүйлгээний тухайд гүйлгээ, харилцагчийн мэдээллийг СГТ-аар СМА-нд мэдээлсэн тухай харилцагчид өөрт нь, мөн эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад этгээдэд хэлэх, мэдэгдэх, мэдээллийг дамжуулах, задруулах нь хуулиар хориглогдсон байдгийг анхаарах хэрэгтэй.

ББСБ шаардлагатай тохиолдолд уг СГТ-тай холбоотой нэмэлт мэдээллийг СМА-нд хүргүүлж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн холбогдох бусад заалтуудыг заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

3.4 ЯАЖ МЭДЭЭЛЭХ ВЭ?

ББСБ нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг СМА-нд мэдээлэхдээ “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-д заасны дагуу тайлан бэлтгэж, цахимаар мэдээлэх үүрэгтэй. СГТ-ийн маягтыг бөглөх дэлгэрэнгүй заавар, мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан “Тайлан бөглөх заавар, зөвлөмж”-д тусгасан байгаа болно.

4 ХАРИЛЦАГЧИЙН ТАЛААРХ БАРИМТ, МАТЕРИАЛЫГ ХАДГАЛАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу ББСБ нь сэжигтэй гүйлгээ болон бусад бүх гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгалах үүрэгтэй.

Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэлд сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогын талаарх мэдээлэл аль аль нь хамаарна.

Хуульд заасан 5 жилийн хугацаа нь сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлого хийгдсэнээс хойш тооцогдоно. ББСБ нь сэжигтэй гүйлгээний

тухай мэдээлэл болон түүнтэй холбогдох бусад баримт бичгийг СМА болон хуульд заасан бусад эрх бүхий байгууллагын мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай, тухайн гүйлгээтэй холбоотой мэдээллийг сэргээж харах боломжтой, холбогдох бүх мэдээллийг агуулсан байхаар хадгалах шаардлагатай.

5 УДИРДЛАГА БОЛОН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

ББСБ нь удирдах болон гүйцэтгэх шатны ажилтнууддаа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан хууль, эрх зүйн актууд болон байгууллагын дотоод бодлого, журмыг танилцуулах, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн хангахтай холбоотой мэдээлэл, чиглэл, заавар өгөх сургалтыг дотооддоо тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан МҮЭ-ийн дотоод хяналтын хөтөлбөрт “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр”-ийг тусгаж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажиллахыг МҮЭ бүрт үүрэг болгосон байгаа. Мэдээж сургалтын хөтөлбөрийг ажилтнуудын хариуцсан ажил, чиг үүрэгт тохируулан ерөнхийлөн эсхүл тусгайлан ялгамжтай боловсруулсан байж болно. Хамгийн гол нь сургалтаар ажилтнуудын хийж байгаа ажил, үүрэгтэй холбогдох хууль, журам, байгууллагын журам, дотоод хяналтын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, цаашлаад тэдний мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмж, гүйцэтгэлийг сайжруулахыг зорьж, хөтөлбөрөө боловсруулах нь зүйтэй.

СГТ-нг мэдээлэхтэй холбогдох чиг үүргийг хэрэгжүүлж буй ажилтнуудын хувьд сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг таних, олж илрүүлэхэд сургах шаардлагатай. Үүнтэй холбогдуулан эдгээр ажилтнууд сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдгүүд болон байгууллагынхаа гаргасан эсхүл олон улсын байгууллагуудаас гаргасан сэжигтэй гүйлгээний жишээнүүдийг уншиж мэдсэн, мөн банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэгддэг арга хэлбэр, типологийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болох нь зүйтэй.

Түүнчлэн сургалтаар хариуцсан ажилтнуудад сэжигтэй байж болзошгүй гүйлгээг илрүүлэх, сэжиглэх үндэслэлийг олж тогтоох зорилгоор гүйлгээ, харилцагчийг сонгох, шалгахтай холбогдуулан ямар арга хэмжээ авч, яаж ажиллах талаар дотооддоо авч хэрэгжүүлэх ажлын дэс дараалал, үйл явцыг тодорхой зааж, сургах шаардлагатай.

Банк, санхүүгийн салбарын бизнесийн орчин, харилцагч болон бүтээгдэхүүний төрөл, хэлбэр, ашиглагдах техник, технологи цаг үеэ даган өөрчлөгдөж байдаг тул сургалтын хөтөлбөрийг бий болох өөрчлөлттэй уялдуулан хууль, журамд орсон өөрчлөлтийг тусгаж тогтмол шинэчлэх шаардлагатай.

Сургалтаар МУТСТ-тэй холбоотой тавигдах хуулийн шаардлагууд, байгууллагын дотоод бодлого, үйл ажиллагаа болон сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн талаарх ажилтнуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхээс гадна ажилтан хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага, гарах үр дагаврын талаар, цаашлаад ажилтан болон байгууллага ямар ямар хариуцлага хүлээх (зөрчлийн шинжээс хамааран эрүүгийн, зөрчлийн хариуцлага хүлээх эсхүл Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу арга хэмжээ авах гэх мэт) талаарх мэдлэг, мэдээллийг ажилтнуудад олгох хэрэгтэй.

Ийнхүү сургалт зохион байгуулах нь ББСБ-ын хувьд МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүх шатанд хангахад маш чухал ач холбогдолтой. Гэхдээ ажилтнууд өөр өөр ажил үүргийн хуваарьтай тул сургалтыг хамааралтай, хамааралгүй бүх ажилтнуудад нэг хэлбэрээр хүргэхээс зайлсхийж, сургалтын хөтөлбөрөө МУТСТ-тэй холбоотой чиг үүрэг хэрэгжүүлдэг ажилтнуудад илүү нарийвчилсан, дэлгэрэнгүй байдлаар заахаар боловсруулж, зохион байгуулах нь илүү үр дүнтэй.

5.1 СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалт нь дараах агуулгыг хамарсан байвал зохино. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хянаж зохицуулах болсон талаарх ерөнхий мэдээлэл болон түүх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох, яагаад болон яаж үйлдэгддэг, яагаад энэ төрлийн гэмт хэргүүдийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх шаардлагатай талаарх мэдээлэл;
- Олон улсын стандарт, шаардлагууд;
- Банк, санхүүгийн салбарыг ашиглан Монгол Улсад болон бизнес, санхүүгийн харилцаа их хийгдэж байгаа улс орнуудад МУТС гэмт хэрэг үйлдэгдэж байгаа арга хэлбэр, хэв шинж, типологиуд;
- Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа МУТСТ хууль, журам болон зохицуулах, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын гаргасан гарын авлага, заавар зөвлөмж;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох Үндэсний эрсдэлийн үнэлгээ;
- Байгууллагын эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон МУТС-тэй холбогдох эрсдэлүүд;
- ББСБ-ын дотоод хяналтын нэгж болон хяналт тавих эрх бүхий байгууллагын хийсэн хяналт шалгалтаар илэрсэн МУТСТ-тэй холбоотой асуудлууд, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- ББСБ-ын ажилтнуудын (нягтлан, үйлчилгээний ажилтан, комплаенсын ажилтан, бусад ажилтнууд, ахлах ажилтан, захирал, ТУЗ гэх мэт) МУТСТ-тэй холбоотой үүрэг, хариуцлага, чиг үүргээ хэрэгжүүлэх, ажлаа хийх явцад тулгарч болох түгээмэл асуудлуудыг шийдвэрлэх арга зам.

Жишээ нь:

- Сэжигтэй харилцагчид үйлчилгээ үзүүлэх болон сэжигтэй гүйлгээ хийх үед хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаар удирдамж, чиглэл өгөх;

- Харилцагч, гүйлгээг таньж мэдэхтэй холбогдуулан ББСБ-ын ажилтны тавьсан асуулт, хүсэлтэд нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга өгөхөөс илт зайлсхийж буй харилцагчтай хэрхэн харилцах;
- Харилцагчийн мэдээллийг тодруулах, тулгаж баталгаажуулах болон харилцагчийг таньж мэдэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэх мэт ББСБ-ын дотоод бодлого, үйл ажиллагааг таниулах;
- Хууль тогтоомжид заасан харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалахтай холбоотой зохицуулалтыг таниулах;
- Сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгөх;
- Бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэхэд тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгөх;
- Ажилтнуудын хүлээх үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл өгөх;
- ББСБ-ын хэрэгжүүлэх МУТСТ хөтөлбөр болон дотоод бодлого, журмыг танилцуулах.

5.2 СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ БОЛОН ДАВТАМЖ

Сургалт нь зөвхөн шинээр орж ирсэн ажилтнуудад зориулан зохион байгуулдаг нэг удаагийн ажил биш, давтан зохион байгуулагддаг, төлөвлөгөөт ажил байх шаардлагатай. Сургалтыг олон хэлбэрээр, тогтмол зохион байгуулбал илүү үр дүнтэй. Сургалт зохион байгуулах олон арга хэлбэр байдаг бөгөөд заримыг нь энд дурдъя. Үүнд:

- Танхимын сургалт эсхүл ББСБ-ын бүх ажилтнууд үе шаттайгаар ээлж дараалан хамрагдах боломжтой цахим сургалт зохион байгуулах;
- Бүх ажилтнуудад зориулан тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, журам, заавар, холбогдох бусад мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулах, цахим шуудангаар илгээх эсхүл сонин, сэтгүүл гэх мэт товхимол болгон нийтэлж хүргэх. Ингэснээр ажилтнууд хууль тогтоомж, байгууллагын дотоод бодлого, үйл ажиллагаа, эрсдэлийн талаар байнга мэдээлэлтэй байх боломжтой;
- Нэгж /газар, хэлтэс, алба гэх мэт/-ийн үйл ажиллагаатай холбоотой ажил, асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх уулзалт, хурлыг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол зохион байгуулах;
- Компаенсын ажилтнууд (тухайн ББСБ-ын болон бусад байгууллагын) бусад ажилтнуудад зориулан МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох мэдээлэл, заавар зөвлөмж өгөх сургалт эсхүл танилцуулга зохион байгуулах;
- ББСБ-ын удирдлагын багаас ажилтнуудад МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох мэдээлэл, танилцуулга хийх;
- Удирдлагууд болон ажилтнуудад МУТСТ-тэй холбоотой тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар тогтмол мэдээлж байх байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулж танилцуулах.

6 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

6.1 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Харилцагчийн хийсэн, хийж байгаа, эсхүл хийх гэж байгаа гүйлгээ нь хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг эсхүл гэмт хэрэгтэнтэй холбоотой байж болзошгүй хэмээн сэжиг төрүүлэхүйц, хэвийн бус, анхаарал татсан хэв маяг, шинж байдалтай байж болно. Гүйлгээний ийм хэв маяг, шинж байдлыг ерөнхийд нь сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг гэнэ.

ББСБ-ын ажилтнууд өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой сэжигтэй, анхаарал татахуйц шинж тэмдгүүдийг мэддэг, таньдаг байх нь чухал. Энэ нь харилцагчийн гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого сэжигтэй байгаа эсэхийг тодорхойлоход тус дөхөм болох юм.

Гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого нь нэг эсвэл түүнээс дээш сэжигтэй байж болзошгүй шинж тэмдэгтэй байх нь тухайн гүйлгээ нь хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг эсхүл гэмт хэрэгтэнтэй холбоотойг нотлох мэдээлэл болж чадахгүй ч сэжиглэх үндэслэл байгааг илтгэнэ. Олон шинэ тэмдэгтэй байх нь тухайн гүйлгээ, харилцагчийг нэмж судлах шаардлагатай болохыг харуулж буй анхааруулах дохио гэж ойлгож болно. Ийм гүйлгээ, харилцагчийг комплаенсын ажилтан нарийвчлан шалгаж сэжиглэх бодитой үндэслэл байхгүй эсхүл байгаа эсэхийг шийдэх бөгөөд сэжиглэх үндэслэлтэй гэж үзвэл холбогдох журмын дагуу СМА-нд СГТ-аар мэдээнэ.

СМА-наас сэжигтэй гүйлгээний шинж тэмдгийн жагсаалтыг ФАТФ, гадаад улсын СМА болон эрх бүхий байгууллагуудаас гаргасан баримт бичиг, мөн өнгөрсөн хугацаанд МҮЭ-ээс СМА-нд мэдээлсэн сэжигтэй гүйлгээний мэдээлэлд үндэслэн боловсруулж, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд” гэсэн баримт бичиг гаргасан бөгөөд цахим хуудаст байршуулсан байгаа. ББСБ-ын ажилтнууд тэдгээр сэжигтэй гүйлгээний жишээ, шинж тэмдгүүдийг энэ гарын авлагатай хамт үйл ажиллагаандаа ашиглана уу.

Гэмт хэрэгтнүүд болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд өөр өөр салбар дахь сул талуудыг ашиглах зорилгоор, мөн шинэ техник, технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрэх тутам өөрсдийн зан байдал, үйлдэл, гэмт хэрэг үйлдэх арга хэлбэрээ байнга өөрчилдөг болохыг харгалзан ББСБ-ын ажилтнууд мэдлэг мэдээлэлтэй, сонор сэрэмжтэй ажиллах хэрэгтэй.

7 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

СМА нь СГТ-аар мэдээлэгдсэн сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах шаардлагатай эсэхэд дүн шинжилгээ хийхийн тулд МҮЭ-ээс нэмэлт мэдээлэл авах шаардлагатай болдог. Нэмэлт мэдээлэл нь сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагаа нь аль нэг төрлийн гэмт хэрэгтэй холбоотой эсэх, тухайн гүйлгээ, мэдээллийг цааш нь шалгах, хүн хүч, цаг зав, хөрөнгө гэх мэт нөөц зарцуулах шаардлагатай эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг.

7.1 МУТСТ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ АВАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу СМА нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, ББСБ-ын харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг тус хуулийн 4.1-д заасан этгээдээс гаргуулан авах эрхтэй.

СМА-наас сэжигтэй гүйлгээний тухай нэмэлт мэдээлэл авах, ББСБ-нд хүсэлт хүргүүлэх арга, хэлбэр болон ББСБ-наас хариу ирүүлэх арга, хэлбэр, хугацаа зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-326 дугаартай тушаалаар батлагдсан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-д тодорхой тусгасан байгаа.

8 ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

ББСБ нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг боловсруулах, илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой тодорхой, ойлгомжтой дотоод бодлого, журам, үйл ажиллагааны заавар болон хяналтын механизмтай байх шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй бол зөрчлийн шинжээс хамааран МУТСТ тухай хуулийн 23 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйл, Эрүүгийн хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

9 МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ЗАДРУУЛАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу МҮЭ, түүний удирдлага болон ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг тус хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

10 ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн хувь хүн болон хуулийн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.

12.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл

өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

12.3.Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан болон Санхүүгийн мэдээллийн алба, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

_____оОо_____